

## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2018 оны 7 сарын дугаар

### Талархал

2018 оны 7 дугаар сард Япон улсын баруун хэсэгт хүчтэй аадар бороо орсны улмаас ихээхэн хэмжээний хохирол учирсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын харьяа байгууллагууд болон ард иргэдээс ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газарт хандан чин сэтгэлийн дэмжлэг тусламж үзүүлэх талаар нэлээд хүсэлтүүдийг хүлээн авсан билээ. Монгол улсад Баяр Наадмын үе тохиож байсан хэдий ч хохирол амссан Японы ард түмний төлөө дотно сэтгэлээр хандан, санаа тавьсан явдалд та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд та бүхний халуун сэтгэлийг энэхүү мэдээллийн хуудсаар дамжуулан Японы уншигчдад хүргэж байна.

### Тэргүүн Мэдээ

#### Улаанбаатарт Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал болов.



7 дугаар сарын 3-наас 6-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Гамшгийн эрсдлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал болж, 50 гаруй орны 3000 төлөөлөгч оролцон, гамшгийн эрсдлийг бууруулах зорилго бүхий “Улаанбаатарын тунхаглал”-ыг батлан гаргаж, амжилттай өндөрлөв. ЖАЙКА-ийн зүгээс техникийн хуралдаануудыг төлөвлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, Сүхбаатарын талбайд үзэсгэлэнгийн павилон гаргаснаас гадна ЖАЙКА-ийн ажилтнууд энэхүү арга хэмжээнүүдэд өргөнөөр оролцож, гамшгаас хамгаалах салбарт ЖАЙКА-ийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Монголд хэрэгжүүлж ирсэн гамшгаас хамгаалах чиглэлийн төслүүдийн үр дүнгийн талаар танилцуулав.

### Төслийн хэрэгжилт

#### “Хүүхэд хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн 2-р шатыг хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурав.



2018 оны 6 сарын 29-ний өдөр Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, Японы Хүүхдийг Ивээх Сан, ЖАЙКА-ийн холбогдох албаны хүмүүс “Өвсний үндэс” ТХА-ны “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь төсөл”-ийн хоёрдугаар шатыг хэрэгжүүлэх тухай Санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү төсөл нь 2018 оны 3 дугаар сард хэрэгжиж дууссан төслийн 2-р шат бөгөөд засаг захиргааны бүх шатанд хүүхдийн хүчирхийлэл, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах төрийн байгууллагын чадавхи, үйлчилгээг бэхжүүлэхийн хамт хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгааллын талаархи ойлголтыг гүнзгийрүүлэх зорилготой юм.

#### “Уушги тоосжих болон Асбестийн шалтгаант уушги амьсгалын замын өвчлөлийг эрт илрүүлэх оношилгооны чадавхийг сайжруулах төсөл” хэрэгжиж эхэллээ.



7 сарын 4-ний өдрөөс 6-ны өдөр хүртэл “Өвсний үндэс” ТХА –ны “Уушги тоосжих болон Асбестийн шалтгаант амьсгалын замын өвчлөлийг эрт илрүүлэх оношилгооны чадавхийг сайжруулах төсөл”-ийн (Япон талын хэрэгжүүлэгч байгууллага: Institute of Support Center of Remote Medicine. Алсын зайн оношилгоо эмчилгээг дэмжих нэгдсэн төв) хүрээнд эмгэг судлалын оношилгооны сургалтыг зохион байгууллаа. Энэхүү төсөл нь 2018 оны 6 дугаар сард хэрэгжиж эхэлсэн бөгөөд 3 жилийн хугацаанд, уурхайн ажилчдын уушги тоосжих өвчлөл болон шилэн хөвөнтэй хамааралтай ажиллаж буй үйлдвэрийн ажилчид, үүнд хамааралтай нөхцөлд байгаа оршин суугчдын амьсгалын замын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт үеийн оношилгооны чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн

ажиллах юм. Энэ удаагийн сургалтанд Улаанбаатар хот болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эмгэг судлаач эмч, техникч нийт 35 хүн оролцсон бөгөөд оролцогчид Япон мэргэжилтний лекцийг идэвхтэй сонсон хүлээн авч, цаашдын төслийн үйл ажиллагааны өндөр хүлээлттэй боллоо.

### **Мал эмнэлгийн төслийн хүрээнд үнээний зохиомол хээлтүүлгийн чиглэлээр мэргэжлийн сургалт зохион байгууллаа.**



Техникийн хамтын ажиллагааны “Мал эмнэлэг, Мал аж ахуйн салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд малын зохиомол хээлтүүлгийн мэргэжлийн ур чадвар олгох чиглэлээр 6 сарын 25-29-ний өдрүүдэд мэргэжилтэн Нагано Монголд ажиллаа. Тус мэргэжилтэн нь төслийн үйл ажиллагаанд байнга оролцож ирсэн бөгөөд 2017 онд Монголд анх удаа биеийн гадна орчинд үр тогтоон, хөврөл өсгөвөрлөх аргаар ихэр хурга гарган авах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн юм. Энэ удаад үнээн дээр зохиомол хээлтүүлэг хийх практик сургалтаас гадна ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн багш нар хөдөө орон нутгийн малын эмч нарт сургалт явуулах зэрэг төслийн Монгол талын оролцогчдын практик ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

### **“Шударга өрсөлдөөний орчныг бэхжүүлэх төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны 5-р хурал болов.**



ТХА-ны “Шударга өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл” нь 2018 оны 9 дүгээр сард 3 жилийн үйл ажиллагаагаа өндөрлүүлэх юм. Энэхүү төслийн хүрээнд ШӨХТГ-тай хамтран ажиллаж, Өрсөлдөөний хуулийн нэмэлт өөрчлөлт, улсын байцаагч нарыг чадавхижуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж ирлээ. 6 сарын 21-ний өдөр болсон Хамтарсан зохицуулах хорооны 5-р хурал дээр төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ШӨХТГ-ын байцаагч нарын ур чадварыг дээшлүүлэх зорилт биелсэнийг тэмдэглэхийн хамт Өрсөлдөөний хуулийн талаарх ойлголт болон хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төсөл дуусах хүртэлх хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэхээр тогтов.

### **Бусад төслийн үйл ажиллагаа**

- 7 сарын 18: Төлөөлөгчийн газрын шинэ орлогч даргаар Тамура Эрико томилогдож ирэв.
- 7 сарын 23: Урт хугацааны мэргэжилтэн Ито Цүнэто (Нийгмийн даатгалын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл) томилогдож ирэв.
- 7 сарын 27: Урт хугацааны мэргэжилтэн Кинохара Масатоми (Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төсөл) нутаг буцав.
- 7 сарын 28: Урт хугацааны мэргэжилтэн Ямашита Мамору (Нийгмийн даатгалын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл), Төлөөлөгчийн газрын орлогч дарга асан Савада нар нутаг буцав.

### **Сайн дурын үйл ажиллагаа**

#### **Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга.**

#### **(Халдварт бус өвчнөөс (NCDs) урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажил)**



Гар, шүдээ тогтмол угааж хэвших гэх мэт хүүхдэд чиглэсэн эрүүл ахуйн боловсрол, эх хүүхдийн хүнсний тэжээллэгийг сайжруулах, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сургалт сурталчилгааны арга хэмжээ зэрэг нийгмийн эрүүл ахуйчийн бүс нутагтаа хүргэхийг зорьдог мэдлэг мэдээлэл нь өргөн цар хүрээг хамрах аж. Тэр тусмаа халдварт бус өвчнөөр өвчлөгсөдийн тоо өсөх хандлагатай болж, яаралтай арга хэмжээ авах шаардлага гарч байна. Дундговь аймгийн Эрүүл мэндийн газарт үйл ажиллагаа явуулж буй сайн дурын гишүүн Амэмия Юрико нь (2016 оны 3-р ээлж) насанд хүрэгчдэд чиглэсэн хэт таргалалтаас сэргийлэх сургалт болон асуулга судалгаа явуулан, таргалалтын шалтгааныг тодруулах арга хэмжээ авах зэргээр халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг идэвхтэй явуулж байна.

## Бусад сайн дурын үйл ажиллагаа

- 7 сарын 18-ны өдөр 2018 оны 1-р ээлжийн сайн дурын гишүүн 12 хүн Монголд ирлээ. Сэгүчи Рёо (Волейбол/ Монголын волейболын холбоо), Абэ Ёшими (Дуу хөгжим/ Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар), Урата Юүрико (Биеийн тамир/ Дорнод аймгийн 1-р сургууль), Сакүраги Ёшино (Япон хэл/ Өвөрхангай аймгийн Мэргэд цогцолбор сургууль), Сасаки Манами (Компьютерийн технологи/ Архангай аймгийн 2-р сургууль), Тахара Хироми (Тусгай хэрэгцээт боловсрол/ Дорноговь аймгийн 11-р цэцэрлэг), Хаяасака Михо (Волейбол/ Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургууль), Миязава Мэгүми (Бага ангийн багш/ Дорноговь аймгийн 1-р сургууль), Мотобаяши Михо (Байгалийн ухааны багш/ Дорнод аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар), Ямагүчи Михо (Сургуулийн өмнөх насны боловсрол/ Орхон аймгийн 10-р цэцэрлэг), Ямада Ханаэ (Бага ангийн багш/ Дархан-Уул аймгийн 1-р сургууль), Ямада Юки (Бага ангийн багш/ Дорнод аймгийн 12-р сургууль) нарынхаа сайн дурын үйл ажиллагаанд нь өндөр амжилт хүсье.



## ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо

### ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооноос зохион байгуулдаг өдөрлөг



ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо гишүүд хоорондын нөхөрлөл хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор холбооны гишүүд болон ЖАЙКА-ийн холбогдох хүмүүсийн оролцоотой “Спорт өдөрлөг” болон “Хоолны өдөрлөг”-ийг жил бүр зохион байгуулдаг. Өнгөрсөн жил дээрх 2 арга хэмжээг нэгтгэн нэг өдөрт зохион байгуулж, гар бөмбөг, ширээний теннис тоглон хөлсөө гаргахын зэрэгцээ өөрсдийн авч ирсэн гарын хоолоо бие биедээ танилцуулан, дотно нөхөрлөж, харилцаа холбоогоо улам бэхжүүлж чадсан билээ. Энэ намар явган аялал зохион байгуулахаар төлөвлөж буй тул сонирхсон хүмүүс ирж оролцохыг хүсч байна.



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА) Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg\_oso\_rep@jica.go.jp